



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 1994

Мандалговь

Боловсролын салбарын төсвийн  
шинэчлэлийг удирдлага, арга зүйгээр  
хангах дэд ажлын хэсгийн ахлагчийг  
өөрчлөн томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.2, 27.5.3, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/04 дүгээр тушаалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн боловсролын салбарын төсвийн шинэчлэлийн хэрэгжилтийг удирдлага, мэргэжил арга зүйгээр хангах, зөвлөн туслах чиг үүрэг бүхий дэд ажлын хэсгийн ахлагч аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга А.Нарантуяа нь өөр ажилд шилжсэнтэй холбогдуулан тус дэд ажлын хэсгийн ахлагчаар аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн М.Болор-Эрдэнийг томилсугай.
2. Захирамжийн биелэлтийг хангаж, үр дүн, гүйцэтгэлийг хагас жил тутам танилцуулж ажиллахыг ажлын хэсэг (М.Болор-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

4822100:60